

Мягмаржав овогтой Алтанхундага нь 1987 онд Завхан аймгийн Тосон Цэнгэл суманд төрсөн. 1990 онд Эрдэнэт хотноо шилжин ирж 2005 онд Баян-Өндөр цогцолбор ахлал сургуулийг төгссөн.

2009 онд Улаанбаатар хотод Од Дүрслэх Урлаг Дизайн Технологийн дээд сургуулийг дизайнер мэргэжлээр төгссөн. Багадаа сийлбэр, цоолбор, зураг, дархан гээд гар урлалын бүтээлүүд их хийдэг байсан хэдий ч гэмтэл бэртлийн улмаас баруун гарын мэдрэлийн судас нь тасарж мэдээгүй болсон. Үүний улмаас 2005-2017 он хүртэл гар урлалын бүтээл туурвиж чадаагүй бөгөөд энэхүү хугацаанд Эрдэнэт хотноо 2007-2017 хүртэл “Нүүдэл Продакшн” гэх хүүхдийн байгууллага ажлуулдаг байсан. Тус байгууллага нь урлагаар дамжуулан хүүхдийн хүмүүжил, төлөвшилт, авьяас чадварыг нээж хөгжүүлэх зорилготой 13 төрлийн сургалт явуулж, дүү дүрс бичлэг хийж нийт 3000 гаруй хүүхэд залуучуудыг төгсгөж тайз дэлгэцийн бүтээл, тоглолт, тэмцээн, уралдаан, үзэсгэлэн гэх мэт арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг байсан Эрдэнэт хотын анхны продакшн юм.

Түүний уран бүтээлүүдээс дурьдвал:

- 2008 - “Юутай байсан Монгол яадаш болчихсон юм бэ?” драмын жүжиг
- 2009 - “Чи буруугүй” драмын жүжиг
- 2010 - “Монгол хэмнэл” чөлөөт бүжгийн наадам
- 2010 - “Эрдэнэт хотын анхны маскарад шоу тоглолт”
- 2010 - “Эт Мода” загварын шоу тоглолт
- 2011 - “Энэ бол хайр” бүрэн хэмжээний уран сайхны кино
- 2012 - “Улсын баяр наадмын тоглолт”
- 2013 - “Супэр эмээ” хошин шоу тоглолт
- 2014 - “Face of Erdenet” реалити шоу нэвтрүүлэг
- 2016 - Орхон аймгийн үйлдвэрчний эвлэлийн 40 жилийн ойн баримтат кино
- 2018 - Монгол тулгатны 100 эрхэм нэврүүлэгээр “Хүн” хөрөг зургийн үзэсгэлэн

Түүний гавъяа шагналуудаас дурьдвал:

- 2006 - “Хаврын гоёл 2006” наадмын 2-р байр
- 2009 - “Оны шилдэг оюутан” одон
- 2010 - Монголын залуучуудын холбооны “Соёрхол тэмдэг”
- 2010 - НҮБ-ын Дэлхийн Энх Тайвны Төлөө Нийгэмлэгийн “Энхийн төлөө одон”
- 2012 - Хүүхдийн Төлөө Төвийн “Хүүхдийн хайртай багш” медаль
- 2012 - Эрдэнэт хотын Засаг даргын “Жуух бичиг”
- 2016 - Эрдэнэт хотын “40 жилийн ойн медаль”
- 2016 - Эрдэнэт хотын Үйлдвэрчний эвлэлийн “Хүндэт жуух”
- 2016 - Эрдэнэт хотын Үйлдвэрчний Эвлэлийн “40 жилийн ойн медаль”
- 2016 - Монголын Үйлдвэрчний Эвлэлийн “Хүндэт тэмдэг”
- 2018 - Монгол Улсын Соёлын Тэргүүний ажилтан